

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан үйл ажиллагаа	Зорилт, үйл ажиллагаа	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Хийгдсэн ажлууд	Өмнөх долоо хоногийн хэрэгжилт ийн хувь	Энэ долоо хоногийн хэрэгжилт ийн хувь	Хүлээгдэж буй ажлууд	Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал	Хариуцах байгууллага
0		1	2	3	4	5	6	7	8	9
4.2.2.	Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	Налайх барилгын материалын үйлдвэр технологийн парк байгуулна.	2022	2025	- Цахилгаан хангамжийн БУ-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын БУА дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил Дэд станцаас паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил бүрэн дуусаж техникийн комисс ажилласан бөгөөд цахилгааны горимын тооцоол хийгдэж, техникийн комиссоос өгсөн үүрэг даалгавруудыг бүрэн хийж дуусган улсын комисс ажиллаж хүлээж авсан. - Паркийн дулааны станц барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2026 оны төсөв, МУ-ын 2025-2028 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар саналаа хүргүүлсэн. ХББОС-ын яаманд дэд бүтцийн ажлын хөрөнгө оруулалтыг тусгуулах хүсэлт хүргүүлсэн. Дэд бүтцийн төсвийг шинэчлэх ажлын нэмэлт хөрөнгө болох 60,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад албан хүсэлт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад дэд бүтцийн барилга байгууламжуудын хөрөнгө оруулалтыг 2026 оны төсөвт тусгуулах албан бичиг хүргүүлсэн. - Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газар дээр нийт 40 аж ахуй нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт үйлдвэрийн барилга угсралтын ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд бүтээн байгуулалт 85 хувьтай явагдаж байна. Дээрх үйлдвэрүүд ашиглалтад орсноор 325 хүнийг байнгын ажлын	0%	30%	Паркийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн зураг төслүүдийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна.	Паркийн дэд бүтцийн санхүүжилт шаардлагатай байна. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах.	НЗДТГ

Д/д	Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан үйл ажиллагаа	Зорилт, үйл ажиллагаа	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Хийгдсэн ажлууд	Өмнөх долоо хоногийн хэрэгжилт ийн хувь	Энэ долоо хоногийн хэрэгжилт ийн хувь	Хүлээгдэж буй ажлууд	Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал	Хариуцах байгууллага
					байраар хангах ба одоогоор 7 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлээд байна.					

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ